



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>19</sup> он <sup>04</sup> дугаар  
сарын <sup>01</sup>-ны өдөр

Дугаар <sup>1871</sup>  
<sup>1823</sup>

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хавсралт: 5 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТООС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулга 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3-т заасан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно” гэсэн зорилтын хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж буй талаар**

**Хариулт.** Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”- ийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно.” гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг, компанийн бүтцэд хувьцаа (IPO) хариуцсан газар, нэгжийг байгуулан ажиллаж байна.

Хувьцаа (IPO) гадаад зах зээлд арилжих хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- **Нөөц:** Тавантолгойн ордын өргөтгөсөн нөөцийн нэгтгэл тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн байна. Энэхүү нөөцийн нэгтгэл тайлангаар Тавантолгойн ордын нүүрсний нөөцийг 300 сая тонноор нэмэгдүүлсэн болно. Нэмэгдэж батлагдсан нөөцөд тулгуурлан ордыг иж бүрэн ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлээд байна.
- **Дэд бүтэц, төмөр зам:** Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Таван толгой төмөр зам” ХХК-ийг байгуулсан болно.
- **Цахилгаан станц:** Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанаар Оюу толгой төслийг эрчим хүчээр хангах цахилгаан станц барих тухай гэрээнд гарын үсэг зурах эрхийг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт олгосны дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Эрчим хүчний яам болон “Оюу толгой” ХХК Тавантолгойн цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ”-нд гарын үсэг зурсан.
- **Үнэт цаас гаргах бэлтгэл:** Тус бэлтгэлийг хангах хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, компанийн засаглал, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдийн засгийн төслүүд, богино, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, талуудад хүргэхийн зэрэгцээ зах зээлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлын талаарх судалгааны ажлыг гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч мэргэжлийн оролцогчдыг сонгох, хамтарч ажиллах хувилбарыг боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг гадаад зэх зээлд арилжиж хөрөнгө оруулалтыг эрчимжүүлснээр шаардлагатай дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Ингэснээр компанийн орлого, үнэ цэнэ нэмэгдэж, төр, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаа эдийн засгийн эргэлтэд орох боломж бүрдэх юм.

## **Асуулга 2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн цэвэр ашиг 720 тэрбум төгрөгөөс хэдий хэмжээний ногдол ашиг иргэдэд олгох талаар**

**Хариулт.** “Эрдэнэс-Тавантолгой” ХК байгуулагдсан цагаас хойш нийтдээ 192.2 сая м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, нийт 45.92 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулсан байна.

Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны аудитлагдаагүй тайлангаар борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт, улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр нийт 484.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, татварын дараах цэвэр ашиг 801.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал борлуулалтын орлогын хэмжээ 804.5 тэрбум буюу 68 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 340 тэрбум төгрөг буюу 74 хувиар тус тус өссөн байна.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэгт “Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна” гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад “Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой.” гэж, “Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй” гэж заасан байна.

Мөн Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 6 дугаар тэмдэглэлээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ оны эхний улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан болно.

Энэ хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг хэлэлцээд “нэгж хувьцаанд 25 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн 03 дугаар тогтоолыг баталсан болно.

## **Асуулга 3. Нүүрс тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, экспортын орлогыг илүү өсгөхөд чухал ач холбогдолтой шинэ төмөр замыг хэзээ, ямар чиглэлд хэрхэн барих тухайд Засгийн газар ямар бодлого боловсруулж байгаа талаар**

**Хариулт.** Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Таван толгой төмөр зам” ХХК-ийг байгуулсан.

Мөн уг тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-аас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр “Таван толгой төмөр зам” ХХК-д шилжүүлж, “Монголын төмөр зам” ТӨХК-д хувьцаа эзэмшүүлэх, төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг

санхүүжүүлж, хувьцаа эзэмшихийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тус тус даалгасан болно.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэр дэх Тавантолгойн нүүрсний орд газраас Гашуунсухайтын хилийн боомт хүрэх Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн төмөр замын урт 267 км, барилгын ажлын гүйцэтгэх хугацаа 3-4 жил, урьдчилсан тооцоогоор төсөвт өртөг 1.1 тэрбум ам.доллар /*Үүнээс 197.3 сая ам.доллар олгогдсон Үлдэгдэл санхүүжилт 0.9 тэрбум ам.доллар./*, нэвтрүүлэх хүчин чадал жилд 15-30 сая тонн, төмөр замын царигийн өргөн 1435 мм байхаар тооцоо судалгааны ажлууд бүрэн хийгдэж санхүүжилт шийдвэрлэгдсэнээр ТЭЗҮ, зураг төсөлд шинэчлэл хийж, 2019 онд багтаан “Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг шинэчлэн боловсруулж дуусгахаар ажиллаж байгаа болно.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажилд нийт 197.3 сая ам.долларын санхүүжилт хийгдсэн бөгөөд төслийн газар шорооны ажил 86.6%, гүүр, хоолой 52.76%-ийн нийт барилгын ажил 51.84% гүйцэтгэлтэй байна.

Тавантолгойн нүүрсний орд газраас “УБТЗ” ХНН-ийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл нь 2 өртөө, 11 зөрлөгтэй, газар шорооны ажил 43,237,475 м<sup>3</sup>, дөрвөлжин дугуй хоолой 610 ширхэг, барилгын ажлын гүйцэтгэх хугацаа 4-5 жил, урьдчилсан тооцоогоор төсөвт өртөг 1.2 тэрбум ам.доллар, нэвтрүүлэх хүчин чадал жилд 20 сая тонн, төмөр замын царигийн өргөн 1520 мм байхаар урьдчилсан тооцоо судалгаа гарсан.

Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай” 153 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолоор төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг “Дорнын төмөр зам” ХХК хамтран байгуулахаар тусгасан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

**Асуулга 4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар**

**Хариулт.** “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны нэг хэсэг болсон нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 20 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтайгаар байгуулах зорилтыг дэвшүүлж холбогдох техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, 2012 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн.

Өнөөгийн байдлаар уг техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулаад байгаа бөгөөд олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтэц, усан хангамжийн эх үүсвэрийн шийдлийн талаар болон жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэр байгуулах зэрэг асуудлуудыг тусгасан болно.

Уг техник, эдийн засгийн үндэслэлд баяжуулах үйлдвэрийн усан хангамж, бүтээн байгуулалтын хугацаа зэргийг харгалзан үзэж, эхний хэсгийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.

Тус төслийн хэрэгжилтийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээгээр гүйцэтгэх бодлого барьж холбогдох ажлуудыг эхлүүлсэн ба

өнөөгийн байдлаар дээрх төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах олон улсад өндөр нэр хүнд бүхий шилдэг зөвлөхийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Мөн нүүрс гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд эдгээр төслийг урт хугацааны /5-10 жил/ стратегийн төлөвлөгөөнд оруулсан ба хэрхэн хэрэгжүүлэх талаарх судалгааны ажлыг салбарын яам, агентлагтай хамтран гүйцэтгэж байна.

**Асуулга 5. Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн бүс нутгийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах, Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж буй талаар**

**Хариулт.** Эрчим хүчний нэгдсэн систем өвлийн их ачааллын үед нийт суурилагдсан хүчин чадлаа бүрэн ашиглаж байна. Өнгөрсөн өвөл хамгийн их ачаалал 1262 МВт-д хүрснээс төвийн эрчим хүчний системийн оргил ачаалал 1081 МВт хүрч ажилласан. Хэрэглээний өсөлт жилд дунджаар 5 хувь байгаа ба хэрэглээний 76 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээр үйлдвэрлэж, 20 хувийг ОХУ, БНХАУ-аас импортолсон байна.

2017 онд шинээр “Цэцийн салхин станц”, “Моннарангийн нарны станц”, “Эрдэнэт үйлдвэрийн дулааны цахилгаан станц”-ууд, 2018 онд “Нарантээг”, “Сайншандын салхин станц” –ууд тус тус ашиглалтад орж, системийн суурилагдсан хүчин чадлыг 188 МВт-аар нэмэгдүүллээ.

Монгол Улсын эрчим хүчний нийт хэрэглээг 2018-2023 оны түвшинд урьдчилан тооцоход 2018 онд 7186.5 сая кВт.ц, 2023 онд 9382.4 сая кВт.ц байхаар төлөвтэй байгаа ба оргил ачаалал 2018 онд 1360 МВт, 2023 онд 2030 МВт хүрэхээр байна.

Нэгдсэн системд ажиллаж буй эх үүсвэр, импортын эрчим хүч авах дамжуулах шугамын хүчин чадлыг тооцож системийн чадлын дээд хэмжээг 2021 оны түвшинд гаргахад 1605 МВт байгаа тул 2019 оноос эхлэн системийн хэмжээнд чадлын дутагдалд орох нөхцөл байдал үүсэхээр байна.

Өмнөд бүсийн эрчим хүчний системийн нийт хэрэглээний 95 хувийг Оюутолгой төслийн хэрэглээ эзэлж байгаа ба БНХАУ-аас импортоор авч буй эрчим хүчний 99 хувийг тус төсөлд ашиглаж байна. Оюутолгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалт хийгдсэнээр 2020 оны сүүлээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ энергиэрээ 15-20 хувиар нэмэгдэх бол чадлаараа 300-310 МВт хүрэхээр байна.

Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах, үүний дотор төвийн бүсэд дунд болон урт хугацаанд Тавантолгойн ДЦС, Багануурын ДЦС, Бөөрөлжүүтийн ДЦС, Эгийн голын УЦС зэрэг эх үүсвэрийн төслүүдийг эхлүүлсэн ба үүний дотор Тавантолгойн 300 МВт-ын ДЦС-ын төслийг Оюутолгой компанитай хамтран хэрэгжүүлж 2023 онд дуусгахаар “Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ”-г 2018 оны 12 дугаар сарын 31-нд байгуулан, Тавантолгойн Цахилгаан станц ХХК-ийн хөрөнгө оруулалтын гэрээнд холбогдох өөрчлөлтийг оруулахаар ажиллаж байна.

Уг цахилгаан станцыг Тавантолгойн нүүрсний ордод барих бөгөөд дийлэнх

хувийг “Оюу толгой” ХХК эзэмших юм. Ингэснээр Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Өмнөд бүсийн эрчим хүчний хангамжийг дотоодоос хангах боломж бүрдэнэ.

Тавантолгойн ДЦС ашиглалтад орох хүртэл хугацаанд Оюутолгойн уурхайн эрчим хүчний хэрэглээний тодорхой хувийг дотоодын эрчим хүчний эх үүсвэрүүдээс, 2019 онд ашиглалтад орж байгаа Улаанбаатар-Мандалговийн 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар дамжуулан хангах зорилгоор богино хугацаанд хэрэгжих боломжтой төслүүдийг Дархан, Эрдэнэт, Улаанбаатарын ДЦС-уудад хэрэгжүүлж байна.

Баруун бүсийн эрчим хүчний системийн гол эх үүсвэр болох Ховд гол дээр барих Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын талаар 2018 оны 5-р сарын 23-ны өдрийн МУ-ын ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн, төслийг БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын Засгийн Газарт олгож буй 1 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтад оруулан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018.08.30-ны өдрийн 150 дугаар захирамжаар “Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг төслийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах” үүрэг бүхий Эрчим хүчний сайдаар ахлуулсан ажлын хэсэг, Эрчим хүчний сайдын 2018.10.02-ны өдрийн 130 дугаар тушаалаар дэд ажлын хэсгийг байгуулан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг боловсруулан, төсөл эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх талаар БНХАУ-ын компаниудтай харилцан мэдээлэл солилцож ажиллаж байна.

Эрдэнэбүрэнгийн УЦС"-ын судалгааг хийж хамтран ажиллах талаар “Power China” компани, “ЧАЙНА КАМК ИНЖЕНЕРИНГ” компани, “China Water Resources Beifang Investigation, Design and Research Co. Ltd (BIDR)”, “ТВЕА ГРУПП”-ийн зүгээс сонирхлоо илэрхийлсэн, холбогдох уулзалтуудыг тухай бүрд нь хийж байна.

**Асуулга 6. Уул уурхайгаас, тэр дундаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олсон цэвэр орлогоос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр шийдвэртэй арга хэмжээ авахад зарцуулах боломж бий эсэх талаар**

**Хариулт.** Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас түүхий нүүрсийг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн нийслэл хотод оруулахыг хориглох шийдвэрийг гаргасан.

Энэ хүрээнд сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх зорилго бүхий “Таван толгой түлш” ХХК-ийг байгуулсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д нийгмийн хариуцлагын хүрээнд сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх “Таван толгой түлш” ХХК-д шаардагдах санхүүжилтийг олгохыг даалгасан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас эхний ээлжид шаардлагатай санхүүжилтийг “Таван толгой түлш” ХХК-д олгосон бөгөөд цаашид санхүүжилтийн дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэсний үндсэн дээр дараагийн шатны санхүүжилтийг үе шаттай олгохоор төлөвлөж байна.

Уг компани жилд 600 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, Улаанбаатар хотын 220 мянган айл өрхийн хэрэгцээг хангах юм.